Зүрх судасны эмгэгээс урьдчилан сэргийлэхийн тулд баримтлах 9 дүрэм

Тамхины хэрэглээг багасгах

Архины хэрэглээг багасгах

Давсны хэрэглээг багасгах

Дасгал хөдөлгөөн хийх

Бүсэлхийн тойргийг зохих түвшинд барих

Сэтгэл санааг тайван баяр баясгалантай байлгах

Тогтмол шинжилгээ оношилгоонд хамрагдах

Эмчилгээнд тууштай хамрагдах

Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд шууд эмнэлэгт хандах

Чоннам их сургуулийн эмнэлгийн бүсийн зүрх судасны эмгэг судлалын төв

Эмчилгээний төрөл болон цаг захиалга	1899-0000	Цахим цаг захиалга	www.cnuh.com
Цусны эргэлт ба дотрын тасгийн амбулатори	062)220-6263	Зүрх судасны төв	062)220-5412
Мэдрэлийн тасгийн амбулатори	062)220-6178	Тархи судасны төв	062)220-5413
Нөхөн сэргээх, сэргээн засах тасгийн амбулатори	062)220-5198	Тархи зүрхний сэргээн засах төв	062)220-5417
Урьдчилан сэргийлэх төвийн факс	062)220-5418	Урьдчилан сэргийлэх төв	062)220-5410

Чоннам их сургуулийн ОУ-ын эмчилгээний төв

Утасны дугаар	+82-62-220-6016, 6565~6568
Цахим шуудангийн хаяг	imccnuh@gmail.com

Яаралтай тохиолдолд бүсийн кодгүйгээр
119 дугаар уруу залгаарай

전남대학교병원 지정 광주·전남 권역심뇌혈관질환센터 | 보건복지부 | 질병관리본부

*Дараах материалыг зөвшөөрөлгүйгээр аливаа хэлбэрээр ашиглахыг хориглоно

Тархины цус харвалтыг оношлох

- Яаралтай түргэн тусламжийн төвд ирсэн даруй эмч өвчтөний биеийн байдлыг шалгаж тархинд цус харвасан байж шинж тэмдэг хэзээ илэрснийг тогтоож **компьютер томограф(CT)**ийн шинжилгээг яаралтай хийнэ.
- Мөн цусны шинжилгээ, шээсний шинжилгээ болон зүрхний бичлэгийг зайлшгүй хийх бөгөөд мэдрэлийн оношилгоог ч мөн хийх болно.
- Эхний ээлжид богино хугацаанд хийгддэг компьютер томограф шинжилгээгээр цус харвалтын хэлбэрийг тогтоох /цус хомстолын гаралтай(тархины шигдээс) эсвэл цус алдалтаас үүдэлтэй(цус харвалт) эсэхийг тодорхойлох/

Цус алдалтын гаралтай тохиолдолд цус алдаж буй хэсгийн зураг нь цагаан гарна.

Хэрэв цус алдалт байхгүй бол тархины бүтцийг нарийвчилсан соронзон резонанс томограф (MRI) шинжилгээгээр тархины шигдээс эсэхийг тодорхойлно


Тархины шигдээсийн CT оношилгоо


Тархинд цус алдалтын CT оношилгоо


Тархины шигдээсийн MRI оношилгоо


Тархинд цус алдалтын MRI оношилгоо

- Тархины шигдээс байх тохиолдолд судасны байдлыг илүү нарийвчлан шалгах хэрэгтэй бөгөөд MRI оношилгоо хийнэ.



Тархины цус харвалтын эмчилгээ

❶ Тархины шигдээсийн эмчилгээ

- Судас бөглөрч тархины шигдээс болсон тохиолдолд яаралтай эмнэлэгт очих шаардлагатай.
- Шинж тэмдэг илэрснээс хойш 4 цаг 30 минутын дотор бол **цусны шингэлэх (tPA) эмчилгээг хийх боломжтой.** Уг эмчилгээ нь эмээр цусны бүлэгнэлтийг хайлуулдаг үр дүнтэй эмчилгээ юм.


Эмэн эмчилгээний өмнө


Эмэн эмчилгээний дараа

- **Шинж тэмдэг илэрснээс 6 цагийн дотор артерийн судас сэтгүүрдэх (EVT)**мэс ажилбарын эмчилгээ хийнэ.

6 цаг өнгөрсөн тохиолдолд аль болох хурдан эмнэлэгт очих хэрэгтэй бөгөөд цус шингэлэх эмчилгээ хийх боломжгүй ч тархины хавангийн эсрэг болон бусад эмчилгээ(anticoagulant буюу цус бүлэгнэлтийг зогсоох бодис) зэрэг эрт үеийн нөхөн сэргээх эмчилгээ хийж биеийн байдлыг сайжруулах боломжтой.

❷ Тархинд цус алдахад хийх эмчилгээ

- Судас хагарснаар тархинд цус алдаж буй тохиолдолд цус алдаж буй хэсэг болон шалтгаан, цус алдалтын хэмжээ зэрэг өвчтөний биеийн байдлаас хамааран **эмэн эмчилгээ эсвэл мэс заслын эмчилгээ** хийнэ. Цус алдалтын хэмжээ бага байвал цус алдалтыг зогсоох дотрын эмчилгээ хийнэ.

Харин цус алдалтын хэмжээ их байх эсвэл судасны дүрс оношилгоогоор мэс засал хийх шаардлагатай гэж үзвэл мэс заслын эмчилгээг хийдэг.

Ангиографийн аргаар судасны цүлхэн дүүргэгч стент байрлуулж буй зураг

www.gjccvc.co.kr

뇌졸중 [몽골어]

Бүсийн зүрх судасны эмгэг судлалын төв

Тархины цус харвалтын оношилгоо болон эмчилгээ

전남대학교병원
CHONNAM NATIONAL UNIVERSITY HOSPITAL

Тархины цус харвалт гэж юу вэ?

- Тархины цус харвалт гэдэг нь тархины судас бөглөрөх бөгөөд хагарснаар үүсэх тархины судасны эмгэг болно.
- Тархины цус харвалт нь дараах хоёр хэлбэртэй. Тархины судас бөглөрч цус хомстох харвалт буюу тархины шигдээс болон тархины судас хагарч тархи саажих тархины цус харвалт юм.
- Шинж тэмдэг нь төстэй боловч эмчилгээ нь өөр тул CT(Компьютер томограф)болон MRI(соронзон резонанс томограф) шинжилгээ хийлгэж тархины шигдээс уу, цус алдалтын харвалт эсэхийг тодорхойлох нь чухал юм.



Тархины шигдээс
Судас бөглөрч тархи саажих тархины цус харвалт
(Цус хомстлоос үүдэлтэй)



Тархины цус харвалт
Судас хагарч тархи саажих тархины цус харвалт(Цус алдалтаас үүдэлтэй)

Цус харвах эрсдэлд бүлэг

Хянах боломжгүй эрсдэлд бүлэг

- Нас, хүйс, гэр бүлийн өвчний түүх, өвчний түүх

Хянах боломжтой эрсдэлд бүлэг

- Даралт ихсэх
- Чихрийн шижин
- Тамхи татах
- Дислипидеми буюу холестеролийн түвшин хэвийн бус болох (гиперлипидеми буюу липидийн түвшин өсөх)
- Тосгуурын мерцани(нэг төрлийн зүрхний хэм алдагдал)
- Зүрхний хавхлагын эмгэг, Зүрхний бах буюу стенокарди зэрэг зүрхний эмгэг
- Таргалалт
- Дасгал хөдөлгөөний дутагдал
- Тэжээлийн тэнцвэргүй байдал
- Архи дарсны хэт хэрэглээ
- Стресс ядаргаа

Тархины цус харвалтын шинж тэмдэг

- Дараах шинж тэмдэг нь тархины цус харвалттай андуурах магадлалтай шинж тэмдэг болно

1. Гар байнга салганах
2. Гар хөл хүйтэн бээрэх
3. Зовхи татах
4. Гар хөл бадайрч шархирах
5. Хүзүү хөших

- Дээрх шинж тэмдэг илрэх тохиолдолд тархины цус харвалт байх магадлал тийм ч өндөр биш, өөр эмгэгийн шинж тэмдэг байх магадлалтай тул мэргэжлийн эмчид хандахыг зөвлөж байна.

Тархины цус харвалтын ерөнхий шинж тэмдэг

Нүүрний нэг тал мэдээ алдах, саажих



Нэг талын саажилт буюу нэг талын хөл гар хүчгүй болох

Хэл ярианы бэрхшээл буюу ээрэх гацах

Харааны гажиг буюу харц нэг тал уруу хазайх

Цус харвалтын шинж тэмдэг?

Цус харвалттай тэмцэх

5 Five

алхамт кампанит ажил

- Тархинд цус харвах үед хамгийн чухал арга хэмжээ бол **богино хугацаанд(шинж тэмдэг илэрснээс хойш 4 цаг 30минутын дотор) яаралтай түргэн тусламж дуудаж эмнэлэгт хүргэх** явдал юм.
- Хамгийн анхны шинж тэмдэг илэрсэн хугацаа болон нөхцөл байдлыг эмчид тайлбарлаж өгөх
- Зүүгээр хурууны өндөгнүүдийг хатгах үйлдэл хийхээс зайлсхийх хэрэгтэй.
- Хурууны өндөгнүүдийг хатгавал харин ч эсрэгээрээ хоромхон зуур даралтыг ихэсгэж өвчтөний биеийн байдлыг бүр дордуулж болзошгүй тул хэзээ ч хийж болохгүй үйлдэл юм.
- Хамаагүй ус болон тайвшруулах үрэл гэх мэт эм хүчээр уулгавал бөглөрөх бөгөөд амьсгал боогдох эрсдэлтэй тул зайлсхийх хэрэгтэй.
- Зангиа, бүс тэлээ гэх мэт биеийг ороож байгаа зүйлийг тайлж өгвөл амьсгал болон цусны эргэлт сайжирна.